

БАТЛАВ. ХЭРЛЭН ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭЧ
ЖАРГАЛСАЙХАН /

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2016 оны 06 сарын 21 -ны өдөр

Дугаар 04

Чингис хот

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 29.1-д заасны дагуу “Монгол-Ус” Төрийн өмчтөй үйлдвэрийн газрын гаргасан 2016 оны 03-р сарын 02-ны өдрийн 51 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Хэрлэн голын сав газрын захиргааны олгосон 2016 оны 06-р сарын 21-ны өдрийн 06. дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Хэрлэн голын сав газрын захиргааны Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах нэгжийн Усны барилга байгууламж, үйлдвэр, хөдөө аж ахуйн ус ашиглалт хариуцсан мэргэжилтэн Гонгор овогтой Мөнхцог, Ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж, Мигма төвийн 3-р давхар Б хэсэг, улсын бүртгэлийн дугаар 9011094114, регистрийн 2061848 дугаартай “Дацантрейд” ХХК-ий өрөнхий геологич Б.Батнасан нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: MV-015597 тусгай зөвшөөрлийн дугаартай Уртын хөндийн амны алтны шороон орд нь унд ахуйн болон технологийн хэрэгцээнд усны нөөцийг ашиглана.

2.2. Ашиглах усны хэмжээ: 71'796 м³/жил

2.2.1. унд-ахуйд 3,9 м³/хон

2.2.2. үйлдвэрлэлд 4'800 м³/хон

2.3. Усны чанар, найрлага: 2016 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ундны усны эх үүсвэр болох худгаас дээж авч шинжилгээ хийлгэн хариу болон дүгнэлтийг Сав газрын захиргаанд ирүүлнэ. “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт” MNS 900:2005 стандартын шаардлагад нийцсэн усиг унд ахуйд хэрэглэх, шаардлагатай тохиолдол ус цэвэршүүлэх багаж төхөөрөмж сууринуулах

2.4. Усны эх үүсвэрийн байршил: Усны эх үүсвэрийн 2 худагтай,

Солбицол: 1-р худаг 112°12'56" 48°27'46" ундарга 0,5 л/сек тоолуургүй

2-р худаг 112°17'32,1" 48°18'58,7" ундарга 15 л/сек тоолуургүй

Барилга байгууламж: Карьеийн ухлагаас 4500 м³ багтаамжтай тунцаах нуур, 4500 м³ багтаамжтай эргэлтийн усан сан, 4500 м³ багтаамжтай хаягдлын сан, Үерийн усны хамгаалалтын 200-300 м урт суваттай.

Тоног төхөөрөмжийн нэр, марк: Гүний 2 худагтай эргэлтийн усан сангаас DEO2 50/60 маркийн насосоор угаах төхөөрөмж руу ус шахна. Хөрсний шүүрлийн усиг эргэлтийн усан сан руу K160/80 маркын насосоор усиг татна.

2.5. Хаягдал усны хэмжээ:

Хүүхэр чадж болно.

Марж 2018.1.23.

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

Стандартын шаардлага : Хүрээлэн буй орчинд нийлүүлэхдээ цэвэршүүлсэн бохир усны ерөнхий шаардлага MNS 4943:2015-ыг ханган ажиллана.

Хаях цэгийн байршил: Ахуйн бохир усыг хөрсөнд нэвчүүлэн зайлцуулна.

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ. Усны биохимиин шинжилгээний дунг хавсаргана.

Жинлэгдэх бодис, кг

2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин: Унд ахуйн хэрэгцээнээс гарсан хаягдал усыг хөрсөнд нэвчүүлэн зайлцуулж, технологийн хэрэгцээнээс гарсан хаягдал усыг тунаах усан санд хийж эргүүлэн ашиглахаар байна.

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохooс сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ: 2016 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд усны эх үүсвэрийг хамгаалах, байгаль орчныг нөхөн сэргээх чиглэлээр 35.8 сая төгрөг төлөвлөсөн байна.

2.9. Усны тоолуурын: Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-т ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах гэсэн заалт болон БОНХС-ын 2013.05.16-ны өдөр батлагдсан Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журмын 3.6.1, 3.6.2, 3.6.8-д заасны дагуу ус шахаж буй шугам хоолойд 2016 оны 08 дугаар сарын 01 өдрийн дотор баталгаажуулсан тоолуурыг мэргэжлийн байгууллагаар суурилуулсан байна.

Төрөл, нэр, дугаар:

Загвар:

Тоолуурын тоо:

Суурилуулсан байгууллага, огноо:

Баталгаажуулсан байгууллага, огноо:

Тоолуурын заалт:

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

Баяжуулах үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах 71'796 м³ усны нөөцийн төлбөр 56'991'664 /Тавин зургаан сая есөн зүн ерэн нэгэн мянга зургаан зуун жаран дөрөв/ төгрөгийг Хэнтий аймгийн Төрийн сан банкны 180000944 тоот дансанд 2016 оны 10-р сарын 20-ны дотор төвлөрүүлнэ.

Усны тоолуур суурилуулсан өдрөөс эхлэн тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож төсөвт төвлөрүүлнэ.

- Тоолуурын заалтыг Усны тухай хуулийн 19.1 дэх хэсэгт заасны дагуу сар бүрийн 01-ны өдөр Норовлин сумын Байгаль хамгаалагч бичилт хийнэ.
- Тоолуурын бичилт хийснээс хойш 7 хоногийн дотор усны төлбөрийг дансанд төвлөрүүлнэ.
- Усны тоолуур суурилуулахаас өмнөх усны зарцуулалтын хэмжээг БОНХАЖС-ын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тоот тушаалаар батлагдсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-ын дагуу тооцно.

Усны нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлсөн мэдээг ус ашиглалтын тайланд тусгана.

Гурав. Талуудын эрх, үүрэг

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 17.1.9, 7.5, 19.1.2, 26.1, 30.1, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад

- 4.1. Гэрээ нь талуудын гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.
- 4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
- 4.5. Гэрээг доор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.
- 4.5.1. Байгаль орчныг хамгаалах тухай болон Усны тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм журмыг зөрчсөн;
- 4.5.2. Ус ашиглагчийн үүрэг болон гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй;
- 4.5.3. Ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг тогтоосон хугацаанд нь төлөөгүй;
- 4.5.4. Усны тоолуур болон тохиргооны тоног төхөөрөмж сууритуулаагүй буюу ашигласан усны тооцоог хуурамчаар тооцсон;
- 4.5.5. аль нэг тал татан буугдсан бол;
- 4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:


Хэрлэн голын сав газрын захиргааны
Усны барилга байгууламж, үйлдвэр, хөдөө
аж ахуйн ус ашиглалт хариуцсан
мэргэжилтэн

..... /Г.МӨНХЦОГ/

Хаяг: Хаяг: Хэнтий аймаг, Чингис хот,
Хэрлэн сум, "Нийтлэг үйлчилгээ" ОНҮГ-ын
байр, Хэрлэн голын сав газрын захиргаа
Харилцах утас: 70563696, 99650966

Ус ашиглагчийг төлөөлж:

"Дацантрейд" ХХК-ий ерөнхий геологич

..... /Б.БАТНАСАН /

Хаяг: Хэнтий аймаг, Хэрлэн сум 4-р баг
Тэмүүжиний гудамж
Харилцах утас: 326062, 99011725